

"МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ" 23 ДУГААР ТОГТООЛД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ
(Хот байгуулалт, хотын стандартын газар)

2025 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт /өссөн дүнгээр/	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжилт удаашралтай байгаа шалтгаан	Хариуцах байгууллага	Нотлох баримт ирүүлсэн файлын нэр дугаар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
9. ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ										
6	9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.	9.2.3. Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно.	2021 - 2025	19.0 сая төгрөг	-	2022-2023 он: Хөрөнгө шийдвэрлэгдээгүй. 2024 он: Тус стандартын төслийг боловсруулсан. 2025 он: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор UCS1101C:2025 "Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандартыг батлуулав. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор "UCS1101C:2025 Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандарт батлагдсан. Тус стандарт нь 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Тухайн стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд "Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв"-тэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр ногоон эрчим хүчний хэмнэлттэй амины сууцтай болох хүсэлтэй иргэн, хуулийн этгээдтэй "Эрчим хүчний хэмнэлттэй хүлэмжийн хийг бууруулсан ногоон амины орон сууцны чадавхжуулах сургалт"-ыг зохион байгуулж сертификат олгосон.	100	-	Хот байгуулалт, хотын стандартын газар	9.2.3
7	Хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.	9.2.4. Олон Улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	Төсөвгүй	-	2022 он: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор UCS0901B:2022 "Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага" хотын стандарт батлагдсан. 2022 оны 10 дугаар сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 2022-2024 он: Шинээр байгуулсан 135121.3 кв, шинэчлэн засварласан 89497.1 кв талбайг хотын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. 2025 он: Нийт 11680 метр явган болон дугуйн замын батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар болон, Улаанбаатар хотын 6 дүүргийн "Нийтийн эзэмшлийн явган хүний зам, дугуйн замын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар"-д тус тус хотын стандартыг тусгасан. Мөн хотын стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд тохижилт бүтээн байгуулалтын ажлын тендерийн баримт бичиг, ажлын даалгавар, зураг төсөлд батлагдсан хотын стандартыг тусгуулан ажиллаж байна.	100	-	Хот байгуулалт, хотын стандартын газар, Замын хөгжлийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар	9.2.4
10	9.3. Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.	9.3.2. Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	Хөрөнгө шийдвэрлэгдээгүй	-	2021 он: 211 айлын 11 орон сууц буулгаж, 266 айлын 2 орон сууц ашиглалтад орсон. 2022 он: 63 айлын 4 орон сууцыг буулган, 377 айл өрхийн орон сууц ашиглалтад орсон. 2023 он: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын дагуу 2015 оноос хойш Нийслэлийн Засаг даргын 19 удаагийн захирамжаар 178 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах тухай шийдвэр гарсан. Нийт 307 айл өрхийн 3 орон сууц ашиглалтад орсон. 2024 он: Тус чиг үүрэг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар шилжсэн болно.	70	Хөрөнгө шийдвэрлэгдээгүй	Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Хүннү хотын хөгжлийн корпорац ХХК, чиг үүргийн бусад байгууллагууд	9.3. 2022 он 9.3-2023 он Хару (1) 9.3-2023 он Хару (2) 9.3-2023 он Хару (3)
15	9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.	9.5.3. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлж эхэлсэн байна.	2021 - 2025	-	-	2023 онд: НИТХ-ын ээлжит XVI хуралдаанаар баталсан Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх" судалгаа боловсруулах 120.0 сая төгрөгийн төсвийг тусгуулсан. Тус ажлын хүрээнд "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-ийн ТЭЗҮ хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 10 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, НИТХ-д өргөн барьж, 2023 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан. 2024-2025 он: 1. Арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх: Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй ХУД-ийн 20-р хорооны суурьшлын бүсийн арьс шир, завод, ноосны анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг (28 нэгж үйлдвэр, 3 нэгж ноосны үйлдвэр болоод 10 дагалдах үйлдвэр) нүүлгэн шилжүүлэх тухай хэлэлцүүлгийг 2025.04.25-ны өдөр Эмээлт эко үйлдвэрийн паркт зохион байгуулсан. Үүний хүрээнд 4 арьс шир, 1 ноолуур боловсруулах үйлдвэртэй "Паркийн нэгжийн гэрээ" болон "Паркт газар ашиглуулах гэрээ"-г байгуулсан. Мөн Нийслэлийн Ерөнхий Архитекторын санаачлаагаар Хот байгуулалт, хотын стандартын газар болон Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК хамтран ХУД-ийн 20-р хорооны үйлдвэрийн бүсийн хөрс, усны бохирдлыг саармагжуулах, нөхөн сэргээх нь" сэдэвт хаалттай хэлэлцүүлгийг 2025.11.05-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд оролцогч талууд ХУД-ийн 20-р хорооны үйлдвэрийн бүсийн байгаль орчныг нөхөн сэргээх аргачлал, төлөвлөгөө боловсруулж хамтран ажиллахаар болов. 2. Морингийн даваа үйлдвэрлэл технологийн парк байгуулах: Нийслэлийн удирдах ажилтны 2025.06.11-ний өдрийн шуурхай хурлаар НЗД-аас "Морингийн даваа" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлаарх ерөнхий судалгаа боловсруулж танилцуулах үүрэг даалгавар өгөгдсөн. Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулж Морингийн даваан ландшафлын байршил болох Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх байршлыг нэгтгэн 260-300 га газарт эхний ээлжийн төлөвлөлтийн концепци боловсруулж Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогчид танилцуулав. 3. Зах худалдааны төв нүүлгэн шилжүүлэх: Хотын түгжрэл болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж буй зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мега төслүүд, зам тээвэр, логистикийн сүлжээ, өнөөгийн байдлын суурь судалгаанд үндэслэн хот төлөвлөлтийн үндсэн 4 хүчин зүйлсийг харгалзан судалж төвлөрөл, түгжрэл, агаар орчны бохирдолд хамгийн их нөлөөлж буй томоохон 9 зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх төсөл боловсруулсан. Дээрх зах худалдааны төвүүдийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэхэд шаардагдах төсөв санхүүг тооцоолж, үе шат дараатай нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж 2025.02.14-ний өдөр НЗД-ын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадагай-д танилцуулсан. Зах худалдааны төвүүдийн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг НЗД-ын зөвлөлийн хурал болон НИТХ-д танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	90	Хөрөнгө шийдвэрлэгдээгүй	Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Газар зохион байгуулалтын алба	9.5.3

ТАНИЛЦСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА


НЭГТГЭСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Д.ДАШЦЭЦЭГ

Л.ЭНХТУУЛ -С

ЛАДЬЯАСҮРЭН



"МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НОТЛОХ БАРИМТ

2025 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

9.2.3. Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор UCS1101C:2025 "Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандартыг батлуулав. Тус хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд "Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв"-тэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулан, цаашид ААНБ-д "Эрчим хүчний хэмнэлттэй хүлэмжийн хийг бууруулсан ногоон амины орон сууцны чадавхжуулах сургалт"-ыг тус стандартын агуулгыг дагуу оруулан, сертификат олгох чиглэлээр ажиллав.



9.2.4. Олон Улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, ирээдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

Иж бүрэн гудамжинд хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дэхь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дэхь хэсэг, Стандартчилал, төслийн зохицуулалт, тохирлын үнэмлэхүй итгэмжлэлийн тухай хуулийн 10 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах орхыг хангахад чиглэсэн Иж бүрэн гудамж бүтэцт хаммаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS0901B:2022 "Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавихдаг ерөнхий шаардлага" хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS0902B:2022 "Төхөрлийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавихдаг ерөнхий шаардлага" хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS0903B:2022 "Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавихдаг ерөнхий шаардлага" хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөрөөс мөрдсүгэй.

ДАРГА **Ж.БАТБАЯСГАЛАН**


ХОТ

UCS 0901B:2022

ИЖ БҮРЭН ГУДАМЖ

Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага

9.5.3. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлж эхэлсэн байна.



1. Арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх: ХУД-ийн 20 дугаар хорооны суурьшлын бүсийн арьс шир, завод, ноосны анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг /28 нэгж үйлдвэр, 3 нэгж ноосны үйлдвэр болоод 10 дагалдах үйлдвэр/ нүүлгэн шилжүүлэх тухай хэлэлцүүлгийг 2025.04.25-ны өдөр Эмээлт эко үйлдвэрийн паркт зохион байгуулсан.



Мөн Нийслэлийн Ерөнхий Архитекторын санаачлаагаар Хот байгуулалт, хотын стандартын газар болон Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК хамтран "ХУД-ийн 20-р хорооны үйлдвэрийн бүсийн хөрс, усны бохирдлыг саармагжуулах, нөхөн сэргээх нь" сэдэвт хаалттай хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулав.




2. Морингийн даваа үйлдвэрлэл технологийн парк байгуулах: Нийслэлийн удирдах ажилтны 2025.06.11-ний өдрийн шуурхай хурлаар НЗД-аас “Морингийн даваа” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлаарх ерөнхий судалгаа боловсруулж танилцуулах үүрэг даалгавар өгөгдсөн. Морингийн даваан ландфиллын байршил болох Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх байршлыг нэгтгэн 260-300 га газарт эхний ээлжийн төлөвлөлтийн концепци боловсруулж НЗД-ын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогчид танилцуулав.



3. Зах худалдааны төвийг нүүлгэн шилжүүлэх: Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж, зах худалдааны төвүүдийг дагуул хот, эдийн засгийн тусгай бүсэд нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.

Нүүлгэн шилжүүлэх захуудын жагсаалт:

- Наран туул зах;
- 100 айл;
- Барс худалдааны төв;
- Да хүрээ зах;
- Өгөөмөр;
- Хангай зах;
- Хүчитшонхор;
- Гурвалжин;
- Цайз.



(Хот байгуулалт, хотын стандартын газар)